



Аудитын код: САГ-2018/205/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: "Лайэн Аудит" ХХК-ийн аудитор: Г.Дэлгэрцэцэг
Утас: 7012 6778
Цахим хаяг: lionaudit@yahoo.com



Улаанбаатар хот



ҮНДЭСНИЙ АУДИТЫН АГС

15160 Улаанбаатар хотоос
Бага гоируу 3, Засаг газар 10000
Утас: 26-04-33, 4710222-33
E-mail: info@sa.gov.mn

2018.02.26 А. 06/536

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд САГ-2018/205/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсролын хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.


Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Боловсролын хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар 2018 оны 1 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Лайэн аудит” ХХК-ийн аудитор Г.Дэлгэрцэцэг, аудиторын туслах Ү.Цэнджав нар хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв.

Боловсролын хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тус хүрээлэнгийн захирлын 18 тоот албан бичгээр хуулиар тогтоосон хугацаанаас 5 хоног хоцроон 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдөр “Лайэн аудит” ХХК-д ирүүлсэн байна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.



Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Боловсролын хүрээлэн нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага байна” гэж тодорхойлсон бөгөөд боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын асуудлаар байнгын судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх, орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.


Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан нийт 15 сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны нийт зардлын гүйцэтгэлийг суурь болгон авч, түүний 1 хувиар тооцон материаллаг байдлын түвшинг 12,752.4 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-4/



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Боловсролын хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Боловсролын хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS програм ашиглан санхүүгийн тайланг боловсруулж гаргасан байна.

Тав. Дотоод хяналтын талаар

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын нэгжгүй байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар


2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Боловсролын хүрээлэнгийн 2017 онд нийт 1,108,978.2 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй, үүнээс улсын төсвөөс урсгал төсвийн санхүүжилтэд 1,016,841.0 мянга, нэмэлт 208,358.5 мянган төгрөгийн орлого хүлээн авч, төсвийн нийт гүйцэтгэлээр 1,015,726.3 мянган төгрөг зарцуулж, 1,114.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөвт зардлын санхүүжилт болон төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг сар тутам гаргаж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 97,251.9 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Долоо. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:



- Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn-т 2017 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, 2018 оны төсвийн төсөл зэргийг байршуулж олон нийтэд ил тод мэдээлж байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаар

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин болон бараа, ажил үйлчилгээний зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад Боловсролын хүрээлэнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. 27,365.8 мянган төгрөгийн дансны буруу бичилт хийсэн. Үүнд:
 - 2016 оны UNDP-н хэрэгжээгүй төслийн мөнгө 12,377.0 мянган төгрөгийг Сангийн яамнаас буцаан шилжүүлснийг орлого үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогод,
 - дээрхи мөнгийг UNDP-рүү шилжүүлснийг,
 - 2017 онд хэрэгжсэн тэгш хамран сургалттай, эрүүл чанартай сургалтын санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 2,046.3 мянган төгрөгийг,
 - хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн бага ангийн эх хэл болон монгол хэлний сургалтын үр дүнг тандах судалгааны санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 566.0 мянган төгрөгийг тус тус буцаан шилжүүлэхдээ бараа үйлчилгээний бусад зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасныг, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх байх талаар зөвлөмж хүргүүлэх.

2. 2017 оны 11 дүгээр сард сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р тусгай сургуулийн бэлтгэл хөтөлбөр, суралцахуйн удирдамж, дасгал ажлын дэвтэр боловсруулах ажлыг хийсэн бөгөөд тус хүрээлэнгийн нэр бүхий 6 эрдэм шинжилгээний ажилтан уг хөтөлбөр дээр ажиллаж ажлын хөлс авсан атлаа 11 дүгээр сарын үндсэн цалин 4,070.0 мянган төгрөгийг бүтэн бодуулж авсан байна.

Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Дундаж цалин хөлс тодорхойлох журмын 3 дугаар бүлэгт “Үндсэн цалин гэж ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө ажил олгогчоос ажилтанд олгох баталгаат хөлсийг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3. 892.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал хэмээн зардалд бүртгэсэн байна. Үүнд:


- Бичиг хэргийн зардалд 329.0 мянган төгрөгийн цаас устгагч,
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 563.7 мянган төгрөгийн хөшиг зэргийг тус бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3 дугаар бүлгийн 3.1.4-т “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад буюу нэг жилийн дотор сургалт болон бусад үйлчилгээ, захиргааны зориулалтаар ашиглагдах хангамжийн зүйлс, сэлбэг хэрэгсэл болон худалдахаар эзэмшиж буй биет үндсэн хөрөнгийг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 388 дугаар тушаал болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, зөрчлийг арилгах талаар зөвлөмж хүргүүлэх.

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар 2017 оны 11 дүгээр сард сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р тусгай сургуулийн бэлтгэл хөтөлбөр, суралцахуйн удирдамж, дасгал ажлын дэвтэр боловсруулах ажлыг хийсэн бөгөөд тус хүрээлэнгийн нэр бүхий 6 эрдэм шинжилгээний ажилтан уг хөтөлбөр дээр ажиллаж ажлын хөлс авсан атлаа 11 дүгээр сарын үндсэн цалин 4,070.0 мянган төгрөгийг бүтэн бодуулж авсан зөрчлийг залруулах боломжгүй байна.



Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Боловсролын хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Боловсролын хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 32,328.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба уг зөрчлүүдэд 3 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Боловсролын хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас итгэмжлэл олгосон байна.

Арван зургаа. Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитын тайланд хавсралт материал / хуудас/-ыг хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:


Аудитор

Г.Дэлгэрцэцэг

Бэлтгэсэн:

Аудиторын туслах

Огноо: 2018.02.26



Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Боловсролын хүрээлэнгийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Боловсролын хүрээлэнгийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Боловсролын хүрээлэнгийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудиторын ажиглалт

27,365.8 мянган төгрөгийн дансны буруу бичилт хийсэн. Үүнд:

- 2016 оны UNDP-н хэрэгжээгүй төслийн мөнгө 12,377.0 мянган төгрөгийг Сангийн яамнаас буцаан шилжүүлснийг орлого үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогод,
- дээрхи мөнгийг UNDP-рүү шилжүүлснийг,
- 2017 онд хэрэгжсэн тэгш хамран сургалттай, эрүүл чанартай сургалтын санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 2,046.3 мянган төгрөгийг,
- хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн бага ангийн эх хэл болон монгол хэлний сургалтын үр дүнг тандах судалгааны санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 566.0 мянган төгрөгийг тус тус буцаан шилжүүлэхдээ бараа үйлчилгээний бусад зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасныг, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

Зөвлөмжүүд

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалыг хэрэгжүүлж,
- цаашид зөрчлийг давтан гаргахгүй.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн зөрчилд хариу өгөх үйл ажиллагаа алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч залруулсан болно.

Аудиторын ажиглалт

2017 оны 11 дүгээр сард сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р тусгай сургуулийн бэлтгэл хөтөлбөр, суралцахуйн удирдамж, дасгал ажлын дэвтэр боловсруулах ажлыг хийсэн бөгөөд тус хүрээлэнгийн нэр бүхий 6 эрдэм шинжилгээний ажилтан уг хөтөлбөр дээр ажиллаж ажлын хөлс авсан атлаа 11 дүгээр сарын үндсэн цалин 4,070.0 мянган төгрөгийг бүтэн бодуулж авсан байна.

Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Дундаж цалин хөлс тодорхойлох журмын 3 дугаар бүлэгт “Үндсэн цалин гэж ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө ажил олгогчоос ажилтанд олгох баталгаат хөлсийг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Дундаж цалин хөлс тодорхойлох журам зөрчигдөх, илүү цалин олгогдох.

Зөвлөмжүүд

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Дундаж цалин хөлс тодорхойлох журмыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудиторын ажиглалт

892.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал хэмээн зардалд бүртгэсэн байна. Үүнд:

- Бичиг хэргийн зардалд 329.0 мянган төгрөгийн цаас устгагч,
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 563.7 мянган төгрөгийн хөшиг зэргийг тус тус бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3 дугаар бүлгийн 3.1.4-т “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад буюу нэг жилийн дотор сургалт болон бусад үйлчилгээ, захиргааны зориулалтаар ашиглагдах хангамжийн зүйлс, сэлбэг хэрэгсэл болон худалдахаар эзэмшиж буй биет үндсэн хөрөнгийг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зөрчигдөх, хөрөнгө дутагдах.

Зөвлөмжүүд

- Сангийн сайдын 388 дугаар тушаал болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах,
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч залруулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	-
АВЛАГА	-	-
Бусад авлага		
УРЬДЧИЛГАА	-	-
Урьдчилж гарсан зардал		
БАРАА МАТЕРИАЛ	4,731,430.00	7,573,130.00
Түүхий эд материал		
Бэлэн бүтээгдэхүүн		
Хангамжийн материал	4,731,430.00	7,573,130.00
Мал, амьтад		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,731,430.00	7,573,130.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	131,167,128.72	94,170,320.28
Биет хөрөнгө	131,167,128.72	94,170,320.28
Барилга, байгууламж		
Хуримтлагдсан элэгдэл		
Авто тээврийн хэрэгсэл		
Хуримтлагдсан элэгдэл		
Машин, тоног төхөөрөмж	169,587,662.00	169,587,662.00
Хуримтлагдсан элэгдэл	-	115,883,809.84
Тавилга, аж ахуйн эд хогшил	62,270,820.00	62,270,820.00
Хуримтлагдсан элэгдэл	-	21,804,351.88
Номын фонд		
Бусад хөрөнгө		
Хасагдуулга		
Биет бус хөрөнгө	-	-
Програм хангамж	1,000,000.00	1,000,000.00
Хасагдуулга	-	1,000,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	131,167,128.72	94,170,320.28
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	135,898,558.72	101,743,450.28
Богино хугацаат өр төлбөр	-	-
Өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	-	
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
Засгийн газрын оруулсан капитал	96,015,446.35	96,015,446.35
Өмнөх үеийн үр дүн	39,883,112.37	39,883,112.37
Тайлант үеийн үр дүн		34,155,108.44
Дахин үнэлгээний зөрүү		
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	135,898,558.72	101,743,450.28
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	135,898,558.72	101,743,450.28

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,048,605,466.82	1,225,199,579.90
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,287,552.00	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,400,000.00	
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	22,887,552.00	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,022,317,914.82	1,225,199,579.90
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,463,835,100.00	1,016,841,048.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	558,482,814.82	208,358,531.90
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	353,104,599.32	208,358,531.90
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	205,378,215.50	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,050,019,627.92	1,259,354,688.34
УРСГАЛ ЗАРДАЛ	2,006,423,587.34	1,232,066,112.02
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,006,423,587.34	1,232,066,112.02
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	676,070,251.90	528,543,402.56
Цалин	543,791,333.00	361,447,802.56
Нэмэгдэл цалин	-	75,857,600.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	35,338,000.00
Гэрээтийн цалин	132,278,918.90	55,900,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,185,161.85	57,996,605.12
Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,580,277.82	41,721,020.09
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,435,464.63	4,253,867.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,436,812.00	3,316,694.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,041,118.50	791,363.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	10,691,488.90	7,913,661.03
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,752,000.00	1,921,900.00
Байрны түрээс	4,752,000.00	1,921,900.00
Хангамж, бараа материалын зардал	6,683,700.00	29,390,800.00
Бичиг хэргийн материал	2,055,400.00	13,892,500.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	1,480,500.00	10,554,500.00
Ном, хэвлэлийн зардал	3,147,800.00	1,386,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс		3,557,800.00
Томилолт, зочны зардал	46,664,453.81	12,417,150.00
Гадаад томилолтын зардал		3,511,250.00
Дотоод томилолтын зардал	46,664,453.81	8,905,900.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,084,312,150.51	549,761,695.90
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,084,312,150.51	549,761,695.90
Бараа үйлчилгээний бусад зардал	115,755,869.27	67,023,358.44
Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,988,800.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	91,454,156.17	15,037,750.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,301,713.10	36,996,808.44
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,596,040.58	27,288,576.32
Бусад урсгал шилжүүлэг	23,348,300.00	26,173,863.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,665,227.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,348,300.00	8,808,636.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		14,700,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,247,740.58	1,114,713.32
Төвлөрүүлэх шилжүүлэг	20,247,740.58	1,114,713.32
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	1,414,161.10	34,155,108.44
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	- 1,414,161.10 -	34,155,108.44

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
20,247,740.58
ЗӨРИТГЭЛ
САНХҮҮЖИЛТ
1,114,713.32

14,700,000.00

1,114,713.32

1,114,713.32

34,155,108.44

34,155,108.44

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,025,717,914.82	1,247,681,214.90
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,400,000.00	712,964.00
Нийтлэг татварын бус орлого	3,400,000.00	712,964.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,400,000.00	712,964.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,400,000.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	712,964.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,022,317,914.82	1,231,979,450.90
Улсын төвлөрсөн төсвөөс	1,463,835,100.00	1,016,841,048.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,463,835,100.00	1,016,841,048.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	558,482,814.82	223,347,331.90
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	353,104,599.32	223,347,331.90
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	205,378,215.50	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		6,779,871.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		6,779,871.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,025,717,914.82	1,247,681,214.90
УРСГАЛ ЗАРДАЛ	2,025,717,914.82	1,247,681,214.90
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,982,121,874.24	1,220,392,638.58
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	676,175,810.76	535,323,273.56
Үндсэн цалин	371,626,162.85	368,227,673.56
Нэмэгдэл	76,623,799.43	75,857,600.00
Унаа хоолны хөнгөлөлт	35,695,000.00	35,338,000.00
Гэрээт ажлын хөлс	192,230,848.48	55,900,000.00
Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	74,380,684.09	57,996,605.12
Тэтгэврийн даатгалын шимтгэл	74,380,684.09	57,996,605.12
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	4,752,000.00	1,921,900.00
Байрны түрээс	4,752,000.00	1,921,900.00
Хангамж, бараа материалын зардал	6,683,700.00	32,232,500.00
Бичиг хэрэг	2,055,400.00	15,979,500.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,480,500.00	10,554,500.00
Ном, хэвлэл	3,147,800.00	1,386,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,312,500.00
Томиллолт, зочны зардал	46,664,453.81	12,417,150.00
Гадаад албан томиллолт		3,511,250.00
Дотоод албан томиллолт	46,664,453.81	8,905,900.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,082,011,069.41	549,761,695.90
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,082,011,069.41	549,761,695.90
Бараа үйлчилгээний бусад зардал	91,454,156.17	30,739,514.00
Бараа үйлчилгээний бусад зардал		15,701,764.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	91,454,156.17	15,037,750.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,596,040.58	27,288,576.32
Бусад урсгал шилжүүлэг	23,348,300.00	26,173,863.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		2,665,227.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,348,300.00	8,808,636.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		14,700,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,247,740.58	1,114,713.32
Төвлөрүүлэх шилжүүлэг	20,247,740.58	1,114,713.32
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

01

ТӨРИЙН АУДИТ ОН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	41,297,273.47	137,312,719.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35	41,297,273.47	137,312,719.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн		- 1,414,161.10	- 1,414,161.10
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	39,883,112.37	135,898,558.72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35	39,883,112.37	135,898,558.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн		- 34,155,108.44	- 34,155,108.44
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	5,728,003.93	101,743,450.28

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ**

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00		
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,112,978,200.00	1,015,726,334.68	97,251,865.32	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,112,978,200.00	1,015,726,334.68	97,251,865.32	91
Бараа, үйлчилгээний зардал	1,083,082,200.00	989,552,471.68	93,529,728.32	91
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,576,900.00	528,543,402.56	33,497.44	100
Үндсэн цалин	361,481,300.00	361,447,802.56	33,497.44	100
Нэмэгдэл	75,857,600.00	75,857,600.00	-	
Унаа, болон бусад нөхөн олговор	35,338,000.00	35,338,000.00	-	
Гэрээт ажлын хөлс	55,900,000.00	55,900,000.00	-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,826,500.00	57,996,605.12	1,829,894.88	
Тэтгэврийн даатгал	38,003,300.00	57,996,605.12	- 19,993,305.12	153
Тэтгэмжийн даатгал	5,455,800.00	-	5,455,800.00	-
ҮОМШӨ ний даатгал	4,364,600.00	-	4,364,600.00	-
Ажилгүйдлийн даатгал	1,091,200.00	-	1,091,200.00	-
Эрүүл мэндийн даатгал	10,911,600.00	-	10,911,600.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	392,000.00	392,000.00	-	100
Байрны түрээс	392,000.00	392,000.00	-	100
Хангамж, бараа материалын зардал	31,103,000.00	31,103,000.00	-	100
Бичиг хэрэг	14,850,000.00	14,850,000.00	-	100
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	10,554,500.00	10,554,500.00	- 0.00	100
Ном, хэвлэл	1,386,000.00	1,386,000.00	-	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,312,500.00	4,312,500.00	-	100
Томилолт, зочны зардал	1,169,200.00	1,162,200.00	7,000.00	99
Дотоод албан томилолт	1,169,200.00	1,162,200.00	7,000.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	456,514,600.00	364,855,264.00	91,659,336.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	456,514,600.00	364,855,264.00	91,659,336.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	5,500,000.00	-	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	5,500,000.00	-	100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,896,000.00	26,173,863.00	3,722,137.00	
Бусад урсгал шилжүүлэг	29,896,000.00	26,173,863.00	3,722,137.00	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	2,665,227.00	334,773.00	
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,596,000.00	8,808,636.00	2,787,364.00	
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	15,300,000.00	14,700,000.00	600,000.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,112,978,200.00	1,015,726,334.68	97,251,865.32	
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,108,978,200.00	1,015,726,334.68	93,251,865.32	
Улсын төсвөөс санхүүжих	1,108,978,200.00	1,015,726,334.68	93,251,865.32	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,000,000.00	-	4,000,000.00	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	-	4,000,000.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	- 0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	- 0.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	51.00	51.00	-	100
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100
Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	-	
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
2017 ОНЫ НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	- 0.00	
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	208,358,531.90	- 208,358,531.90	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	208,358,531.90	- 208,358,531.90	
Бараа, үйлчилгээний зардал	-	208,358,531.90	- 208,358,531.90	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,529,900.00	- 1,529,900.00	
Байрны түрээс	-	1,529,900.00	- 1,529,900.00	
Хангамж, бараа материалын зардал	-	1,129,500.00	- 1,129,500.00	
Бичиг хэрэг	-	1,129,500.00	- 1,129,500.00	
Томилолт, зочны зардал	-	11,254,950.00	- 11,254,950.00	
Гадаад албан томилолт	-	3,511,250.00	- 3,511,250.00	
Дотоод албан томилолт	-	7,743,700.00	- 7,743,700.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	184,906,431.90	- 184,906,431.90	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	184,906,431.90	- 184,906,431.90	
Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,537,750.00	- 9,537,750.00	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	9,537,750.00	- 9,537,750.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	208,358,531.90	- 208,358,531.90	
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	208,358,531.90	- 208,358,531.90	
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	-	208,358,531.90	- 208,358,531.90	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	- 0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	- 0.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	51.00	51.00	-	
Удирдах ажилтан	1.00	1.00	-	
Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	-	
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	
ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	-	
Төрийн захиргааны албан хаагч /ГЗ/	-	-	-	
Төрийн тусгай албан хаагч /ГТ/	-	-	-	
Ажлын албаны албан хаагч /АА/	-	-	-	
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	-	-	-	
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮШУ/	-	-	-	
Соёл урлагын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮ	-	-	-	
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч	-	-	-	
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /	-	-	-	
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	-	-	-	
Гэрээт ажилтан	-	-	-	
Улс төрийн албан хаагч /УТ/	-	-	-	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	51.00	51.00	-	100
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100
Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	-	
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**